

**УИХ-ын 2008 оны ээлжит сонгуульд  
оролцох ЭЧХН-ын мөрийн хөтөлбөр**

**УРИА:**

**МОНГОЛЫГ МОНГОЛООР НЬ ХӨГЖҮҮЛЬЕ!**

**Төрд хяналт хариуцлага, шударга зарчим, түмэнд ажил орлого хэрэгтэй!**

**Мөрийн хөтөлбөрийн зорилго** Улс орноо авилгал, хээл хахууль, хүнд суртал, давхардсан орон тооны асуудал, бусармаг үйлдэл, эмх замбараагүй байдлаас, ард иргэдээ ядууралаас, улс төрийг бизнесээс, төрийн албан хаагчыг намаас салгаж, иргэдэд шууд үйлчилдэг шударга, хариуцлагатай, эрх тэгш, эрх чөлөөт засаглалыг бий болгоно

**ЭЧХН-ын мөрийн хөтөлбөр нь үндсэн ба дэд хэсгээс бүрдэнэ**

**Үндсэн хэсэг**

1. Авилгал хээл хахууль, хүнд сурталтай тууштай тэмцэж, иргэдэд шууд үйлчилдэг засаглал тогтоохын тулд УИХ, төр засагт иргэдийн хяналтын зөвлөл бий болгож, улс төр бизнесийг салгах, хотыг хоггүй, утаагүй болгож, бөөгнөрлийг саармагжуулна.
2. Засаг дарга нарыг иргэд өөрсдөө сонгодог, иргэдийн өдөр тутмын амьдралын үйлчилгээг баталгаажуулах зорилгоор хороодын засаг дарга, нийгмийн ажилтан, эмнэлэг, цагдаагийн хэсгийн үйл ажиллагааг сайжруулж, ИТХ-г жинхэнэ утгаар нь ажиллуулж, эрүүл мэндийн даатгалын хэрэгжилтийг амьд болгож, шүүх засаглал, прокурорыг ерөнхийлөгч томилдог зарчмыг өөрчилж, төндөрийг цэгцлэнэ.
3. УИХ-н гишүүнийг эргүүлэн татдаг эрх зүйн орчин бий болгож, алдаа гаргасан төрийн албан хаагчидтай эрүүгийн хариуцлага тооцож, тэдний тансаглалыг зогсоож, хуулийн өмнө Ерөнхийлөгчөөс иргэн хүртэл нэгэн эрх тэгш байх нөхцлийг бүрдүүлнэ.
4. Монголд гуравдагч орны үйлдвэрлэлийг барьж гуравдагч бүтээгдэхүүнийг захиалагч улсад нь нийлүүлдэг гарц бий болгож өрх, хүн бүрийг орлогын эх үүсвэртэй болгоно

ХЭРЭГ

МОНГОЛ

УИХ

ЭЧХН

2008

5. Өмч хувьчлалыг эргэн харж, иргэдэд дутуу газрыг гүйцээж олгох, үнэгүй олгох хуулийн хугацааг өөрчилж, гандангын бохир, халаалтыг төвийн системтэй холбох асуудлыг цэгцлэнэ. ОСНАА, СӨДЗ, СӨХ-г үйлчилгээг иргэдэд хүргэнэ

6. Ашигт малтмалын лиценцийг цэгцэлж, нутгийн ард иргэдийн оролцоог дээшлүүлж, тэдний шийдвэрийг нь үндэслэж олгодог хууль эрх зүйн орчинг бий болгоно.

7. Хөдөлгөөн ихтэй дүүргүүдийн хороололд газар доор явган зорчигчдын стандартын шаардлага хангасан нүхэн гарц хийж, зам дагуу нийтийн бие засах газартай болгоно.

8. Эрсдлийн сангийн эх үүсвэрийг бий болгож, бэлэнчилэх сэтгэлгээнээс татгалзаж тусгай хөтөлбөр боловсруулж, нэрийн даанс нээж байгалийн баялагаас олох ашгийг хувьцаа хэлбэрээр хувиарлах хууль гаргана, эрсдэлийн санд хамруулахдаа гэмт хэрэг үйлдээгүй, бүрэн дунд боловсролтой байх гэх мэт иргэд өөрсдийгөө боловсруулах энгийн болзолуудыг тавина.

9. "Та зочин бид эзэн нь байя"-гэсэн зарчмаар монгол улсад төрийн айлчлал, хөрөнгө оруулалт хийх, ажиллаж, амьдрах, аялал жуулчлалаар ирэгсэд зочны хэмжээнд байж, монгол улсын иргэнээс дээгүүр эрх ямба эдэлдэггүй байх зарчмыг бий болгож хэрэгжүүлэнэ. Өөрөө хэлбэл бид гадныханд зарцлагдах биш тэдний оюуны нөөцийг ашиглаж байгалийн хөдөө аж ахуйн баялагаа ашиглан иргэн бүр баяжих зарчим баримтлана

### Дэд хөтөлбөр

1. Монголд олон баяр тэмдэглэдэг нь хувийнханд дарамт болж төрийн албаныханд завшаан болдгыг цэгцлэнэ. Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн чанаржуулана.
2. Түрээсийн хуулийг шинэчлэн өөрчилөнө/төлбөрийг төгрөгөөр хийдэг зарчим баримтлана/ орон сууцны ус цахилгааныг таслах асуудал, хувь хүн байгуулага хоорондын мөнгөн шилжүүлэг банк, байгуулагын дотоод асуудал нэрээр хугацаагүй саатдаг тэгсэн мөртлөө иргэдээс авах үед хугацааны алданги тооцдгыг адилтгана.
3. Бидний зохион бүтээсэн "ЭЧХ ба Эрчимт халаагуур"-ыг хэрэглэгч гэр хороололын тоолуурыг зөвхөн шөний тоолуурт шилжүүлэх эсвэл цахилгааны ертгийг 50 %-иар бууруулах асуудлыг хуулчилна.
4. Төрөөс төрсөн "Тэрбумтангууд"-н хөрөнгийн эх үүсвэрийг шалгуулж, хууль бус бол хураалгаж улсын орлого болгож, эрүүгийн хариуцлагад татна.
5. УБ хотын нийтийн тээвэрт өөрчлөлт хийж, метроны нэг шугамтай болгоно.

## Хүний хөгжлийг эрхэмлэх

1. Ерөнхий боловсролын сургуулийн 11, 12 дугаар ангийг мэргэшүүлж, амьдрах арга ухаанд сургах, мэдлэг боловсролоо үр бүтээлтэй ашиглах чадварыг эзэмшүүлэх
2. Хүн амыг экологийн цэвэр, эрүүл аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах нөхцлийг бүрдүүлэн, олон улсын стандартын шаардлагад нийцүүлэх

## Төрийн үйлчилгээг ил тод, шударга, нээлттэй болгох

### 1. Авилгалтай тэмцэх, устгах:

Хүний оролцоогүй үйлчилгээг бий болгох, иргэдийн шилжих хөдөлгөөн болон бусад үйлчилгээг интернетэд шилжүүлэх, луйварчдыг баривчилж шоронд хийх хэрэгтэй, Тухайлбал нэг жишээг хэлмээр байна. ХХБ, Мобисом, ИБМУТ-д үйлчилгээний нэг машин байдгыг бид мэднэ. Тэдгээр машинуудын нэг нь өөрөөр хэлбэл ИБМУТ-ын үйлчилгээний машины дугаарлалтыг нэг цагдаа өгдөг тэр цагдаа иргэдийг хүлээж бай номөр дууссан гэх мэтээр хүндрүүлдэг тэнд нэг ёсны хүнд суртал хээл хахууль явагдаж байна, харин нөгөө газруудад машинуудад иргэд эрх чөлөөтэй өөрсдийнхөө хүслээр үйлчлүүлдэг.Цалингаас доош мөнгө авсан тохиолдолд бол авилгал биш

Өнөөдрийн мөрдөж байгаа хуулиар бол авилгал авсан, өгсөн, зуулчилсан бүгдийг нь ял төлөвлөдөг нь нэг ёсондоо далдуур авилгалыг дэмжсэн явдал. Монголчууд бид багтаж ядсан хөрөнгө, мөнгөтэй болчихоод аагаа багтаагаад авилгал өгөөд байгаа юм биш ажил төрлөө бүтээхийн тулд аргаа барихдаа өгч байгаа юм.Тийм болохоор өгсөн зуулчилснаар илчлүүлж авсанг нь ял төлөвлөдөг байвал авилгалчдыг айлгах болно

### 2. Хүнд сурталтай тэмцэх

Иргэдэд шууд үйлчилдэг засаглалыг бий болгож,олон шат дамжлагыг цөөрүүлэх, шаардлагатай шаардлагагүй журам дүрмийг цэгцлэх, иргэдэд үнэн зөв мэдээлэлийг хүргэх, иргэдэд хүрдэг үйлчилгээг интернөжүүлэх, иргэдтэй зүй бус харьцсан төрийн албан хаагчдыг шууд халдаг, эрүүгийн хариуцлагад татдаг хуулийг бий болгож, үйлчлүүлэнэ.

## Нийгмийн амьдралыг дээшлүүлэх хүрээнд

1. Ганданг утаагүй болгох миний шилдэг төлөвлөгөө маш энгийн, өртөг хямд,та элдэв түлээ нүүрсний төлөө санаа зовох шаардлагагүй болно. Энэ юу вэ гэвэл танайх өвөл түлээ мод хагалж, нүүрс шуудайгаар үүрэх хэрэггүй, тэр ч бүү хэл дугуй, ялтсан сав, гутлын ул түлж, үүнийг бий болгоход цаг хугацаа, хүн хүч хэрэггүй, эдгээр түлээг бэлтгэж хувьцас хунар гар нүүрээ бохир болгож, хүүхэд гэр

бүлтэйгээ түлээ бэлтгэх талаар маргаан гаргах шаардлагайг боллоо. Энэ бол эхний ээлжинд бүх өрхийг цахилгаанаар ажилладаг **ЭЧХ ба Эрчимт халаалт**-тай болгож цахилгааны асуудлыг шийдэх болно. Үүнийг ашигласанаар сард ердийн үеийнхээс нэг дахин бага зардал, ажиллагаа багатай, цэвэрхэн орчинд амьдрана, цахилгааныг шөний тоолуурт шилжүүлэх

2. **ИТХ-г шүүх засаглал, прокурорыг жинхэнэ утгаар нь ажиллуулахдаа:** Монгол улсыг олихархиудаас цэвэрлэж, парламент, төр засаглалд иргэдийн хяналтыг бий болгоно. Төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагчдын хэрэглээ, тансаглал, төрийн өмчийг хянадаг иргэдийн хяналтын хороо байгуулж засаглалд тавих хяналтын чангатгана, харин ийм хяналтын хороо ард иргэнд, хувийн хэвшлийнхэнг хянах эрхгүй байна. СЕХ-ны бүрэлдэхүүнийг сонгоходоо парламентны гаднах намуудаас бүрддэг байх өөрөөр хэлбэл тухайн жилдээ парламентанд суудалтай намаас нэг ч төлөөлөл оролцдоггүй байх хуулийг гаргана. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 4-р зүйлд хорооны гишүүнд нэр дэвшүүлэх, томилох журмын 4.2 –д заахадаа Хорооны гишүүний тавыг УИХ-н төрийн байгуулалтын байнгын хороо, хоёрыг Монгол Улсын Ерөнхийлөгч, хоёрыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор УИХ зургаан жилийн хугацаагаар томилно гэж заасныг өөрчлөн найруулана. Өнөөгийн ИТХ бол иргэдийн төлөөлөгчдын биш эрх баригчдын төлөөлөлийн хурал болсон үүнийг өөрчлөхийн тулд иргэдийн хяналтын хороог байгуулана.

**Шүүх засаглал, прокурорыг шударга ажиллуулахын тулд нэг хүний хараат байдлаас салгаж ерөнхийлөгч томилдог хуулийг хүчингүй болгож, бүх шүүгчдын олонхийн саналаар, мөн засаг дарга нарыг ард түмэн өөрсдөө сонгодог.** Монгол улсын ерөнхийлөгчийн тухай хуулийн 2-р бүлгийн 12-р зүйлийн 16-д Бүх шатны шүүгчийг хуульд заасны дагуу томилно, мөн бүлгийн 17-д Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг томилох тухай саналаа УИХ-д оруулна. УИХ уг саналыг татгалзсан бол өөр хүнийг санал болгоно гэсэн нь Ерөнхийлөгч түүнийг тойрон хүрээлэгчид хуулиас айдаггүй гол шалтгаан үүнд байгаа юм.

3. **УИХ гишүүдийг эргүүлэн татахдаа:** Тойргийн сонгогчид ба нэр дэвшүүлсэн субъект нь эргүүлэн татдаг хуулийг гаргаж, эрхийг нь ард түмний гарт өгнө. УИХ-н гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 10.3 заахдаа УИХ-н гишүүн нь бүрэн эрхийнхээ хугацаанд ба түүнийг дуусгавар болоход хэлсэн үг гаргасан хууль, дэвшүүлсэн саналынхаа төлөө хариуцлага түлээхгүй гээд заасан байдлыг өөрчлөх. УИХ-иар асуудал шийдэхэдээ олонхи гэсэн нэрийн цаана намаараар шийддэг зарчмыг гишүүдийн 1/5 гэсэн хувилбараар шийддэг болгох/

4. **Үйлдвэрлэл барьж, иргэдийн амьжиргааны орлогын эх үүсвэрийг бий болгохдоо:** Том үйлдвэрлэлийг монгол оронд барьж гуравдагч оронтой гэрээгээр үйлдвэрлэлийн барааг нь гаргадаг гарцыг бий болгож, залуучуудыг ажилттай болгож, орлогын эх үүсвэртэй болгоно. Үүний тулд төрөөс эдийн засгийн хөшүүрэг бүхий бодлого явуулана.

6. **Өмч хувьчлалыг эргэн харж, гэр хорооллын газрын тухай маргаантай асуудал, амьжиргааг дээшлүүлэхдээ:** Өмч хувьчлалыг эргэн харж, гэр хорооллын бохир, халаалтыг төвийн системтэй холбох асуудлыг цэгцлэх, ОСНААҮ хариуцлагыг чанаржуулж, бийр орон сууцны халаалтыг хэвийн байлгах,
7. **СӨДЗ, СӨХ-г суугчдынхаа эрх ашгийн төлөө ажилладаг хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хариуцлага тооцдог аргачилалыг бий болгоно.** Газрын тухай /2002.6..7/-ны хуулийн тавьдугаар бүлгийн 29-р зүйлийн 1-д Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр орон сууцны хашаа барих зориулалтаар үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ 0.07 га-гаас илүүгүй байна. Мөн 29.2 –д Энэ хуулийн 29.1- д зааснаас гадна гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар иргэнд 0.1 га-гаас илүүгүй газар үнэ төлбөргүй эзэншүүлж болно гэж заасныг өөрчилж 29.1-д иргэнд дутуу газрыг нөхөн олгоно, 29.2-д зориулалтыг дэлгэрэнгүй, байрны орчимд хүүхэд хөгшдийн газарт барилга барихгүй байх,

**6 Ашигт малтмалын лиценцийг олгохдоо:** Орон нутагт ашигт малтмалын лиценцийг олгохдоо нутгийн ард иргэдийн оролцоог дээшлүүлж, эхний ээлжинд тухайн орон нутгийн иргэд шийдвэрлэдэг түүнийг үндэслэж хайгуулын ба ашиглалтын эрх олгодог хууль эрх зүйн орчинг бий болгоно. Шаардлагагүй олон тооны лиценцийг хүчингүй болгож, байгалийн онгон төрхийг сэргээнэ.

**7. Иргэн бүрд хуулийг тэгш үйлчлүүлэхдээ:** Иргэн бүр хуулийн өмнө эрх тэгш байх ёстой гэсэн зарчмын үүднээс хуулийн үйлчлэлийг Ерөнхийлөгчөөс эхлээд жирийн иргэдэд эрх тэгш үйлчилдэг болгоно.

**8 . Эрсдэлийн сан байгуулахдаа:** Иргэдийн өдөр тутмын амьдралыг баталгаажуулах зорилгоор хороодын зсаг дарга, түүнийг туслах, хэсгийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, иргэдэд шуурхай үйлчилдэг болгох, хувь хүвий нэр дээр нэрийн даанс нээж байгалийн баялгаас олох ашгийг хувьцаа хэлбэрээр хувиарлах хууль гаргана, тэгэхэдээ эрсдэлийн санд хамруулахдаа хууль гаргасан тухайн өдрөөс хойш гэмт хэрэг үйлддээгүй байх, 12 жилийн боловсролтой байх гэх мэт иргэд өөрсдийгөө боловсруулсан байх энгийн болзолуудыг тавина.

**9. Монгол улсад гадаадаас ирэгсэдтэй та зочин шиг зочин бай, би эзэн нь шиг эзэн бай гэсэн зарчмыг баримтлахдаа:** Монгол улсад төрийн айлчлал, хөрөнгө оруулах, ажиллах, сурах, амьдрах, аялал жуулчлалаар ирсэн хэн ч байсан зочны хэмжээнд байж, монгол улсын иргэнээс дээгүүр эрх ямба эдэлдэггүй байх зарчмыг бий болгож хэрэгжүүлэнэ./Та зочин шиг зочин бай, би эзэн нь шиг эзэн бай гэсэн зарчмыг баримтлана

Монголчууд үнэхээр сэтгэлийн агуу сайхан баялагтай оюунлаг ард түмэн юм. Иргэд маань хариуцлагатай шударга төртэй байх юм бол ямар ч засгийн газар, ерөнхийлөгч, их хурлаас илүүтэйгээр өөрсдийнхөө амьдралыг аваад явна төднийг төлөөлсөн төлөөлөл сайн байвал улс орны бодлого иргэдын амьдралд тус

болно. Улс төрч ямар ч нөхцөлд мянган хүнтэй тэнцэхээр сэтгэж чаддаг байх ёстой тийм улс төрч ард иргэдийнхээ байр суурь хүсэн хүлээж байгаа зүйлийг ойлгож хамгаалаж чаддаг, дуу хоолой нь болсон зовлон жаргалыг нь ойлгодог элч төлөөлөл болж чадна.

Өнөөгийн Монголын төрд намын бодлого хэт намчирхсан үзэл дутаагүй харин ард иргэдийн дуу хоолой болж чадах, тэдний сэтгэлийг ойлгодог улс төрч, иргэдийн төлөө зүтгэх зүтгэл, хэлж ярих дуу хоолой маш их дутаж байгаа учир түүнийг нөхөж чадах иргэдийн шудрага төлөөлөл үгүйлэгдэж байна .

Төрийн үйл ажиллагааг эрх мэдэлтэн, аль нэг намын төлөө үйлчилдэг байдлаас салангид байлгаж жинхэнэ утгаараа ард иргэдэд үйлчилдэг болгоно. Нэн ядуурал өлсгөлөнг арилгах, хүмүүсийн тэгш харилцааг хангах, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, хүүхдийн эндэгдлийг багасгах, эх үрийн эрүүл мэндийг сайжруулах, ДОХ бэлгийн замын өвчнийг багасгах, халдварт өвчинтэй тэмцэх ,байгаль орчны тогтвортой байдлыг хангах хууль эрх зүйн орчныг бий болгоно.

### Баримтлах есөн зарчим:

1. Шударга, ил тод, хариуцлагатай байж. хариуцлагын төлөө шийтгэл хүлээх чадвартай байх, хувийн өндөр зохион байгуулалттай байх.
2. Алдаагаа давтахгүй харин алдаан дээрээ суралцдаг, мэдээллийн зуунд газрын хол, цаг хугацааны урт гэж байдаггүй тул мэдээллийг олж авч түүнийг гүйцэд ашиглаж, бусадтай солилцох, бусдаас мэдэж авахыг хичээдэг
3. Өөрийнхөө бөлон бусдын мэдлэг боловсролыг үргэлж дээшлүүлэхэд цаг хугацаа зарцуулж, өөрийгөө хөгжүүлж, онолоос олж авсан мэдлэгээ ажил болгодог байх,
4. Санаачлагатай, харилцааны соёлтой, ур чадвартай, түүнийгээ хөгжүүлэх, мөн цаг үеийн араншинг мэдрэх чадвартай үргэлж шинийг эрэлхийлдэг байх,
5. Бусдыг сонсож, бусдад хүлээцтэй ханддаг, бусдаас олж авахыг эрмэлзэж, өөрийнхөө оюуны хүч чадал, чадвар шингэсэн бүтээгдэхүүн экспортлодог
6. Өөрийгөө үнэн зов илэрхийлэх, хувийн цэгцтэй сахилга баттай байх, бусадтай хэлхээ холбоогоо өргөжүүлж, шинэ санаа шинэчлэлээр дүүрэн байхыг хичээдэг.
7. Эрсдэлийг урьдчилан тооцоолж, түүнээс гарах зохион байгуулалтын өндөр чадвар, хурдтай байх, эрсдэлээс ашгийг, ашгаас эрсдэлийг олж чаддаг, бусдын ололттой давуу талаас суралцдаг .
8. Хуулийг эрхэмлэн дээдэлж, хэрэгжилтэнд нь хяналт тавих, багаар ажиллах, ажлынхаа үр дүнг үзэх талаар тууштай шаргуу байх,
9. Эдийн засаг, санхүүгийн тооцоотой байх, үрэлгэн хайнга, хайхрамжгүй байдлыг тэвчдэггүй. ямар ч үед санхүүгийн нөөцтөй байх ...

“ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ” НАМ

### “Иргэний хөтөлбөр 1-2-3”

#### Иргэний Эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр

1. Хяналттай төр
2. Амьжиргаатай өрх
3. Эзэнтэй нутаг

Удаагийн УИХ-ын сонгууль нь жирийн нэг ээлжит сонгууль биш, Монголын нийгмийн хямралыг гэтлэн  
 явах их үйлсийн эхлэл болно гэж бид үзэж байна. Энэхүү түүхэн сорилт нь улс үндэстнээ аврах, Монголд  
 нийгмийг төлөвшүүлэх, бодит ардчилалыг тогтоох стратегийн зорилгоор тодорхойлогдоно. Үүний тулд:

- ✓ Улс төрийн тогтолцооны өнөөгийн гаж, бурангуй байгууламж, бүтэц, үйл ажиллагаа, арга барил зэргийг  
 бүхэлд нь өөрчлөн шишээлэх, эрх зүйт ардчилсан, шударга төрийг цэгцлэн байгуулах
- ✓ Шилжилтийн үед эрх мэдлийг хахуульдан авсан улс төрийн тодорхой бүлэглэл, бие хүмүүсийн  
 хуйвалдааныг таслан зогсоож, тэдэнтэй хариуцлага тооцох, тэднийг улс төрийн талбараас зайлуулах  
 ажиллыг хэрэгжүүлэх шаардлагатай болж байна.

Нийгмийн хямралыг өдөөгч гол хүчин зүйл бол төрд шургалж, нийгмийг удирдах нь байтугай, ард түмнийг байнга  
 үүрэн мэхэлж, луйвардаж ирсэн, үндэсний ашиг сонирхолд ноцтой хохирол учруулагч цөөн тооны олигархи  
 ажилчид бүлэглэлүүд мөн.

Бүлэглэлүүд зөрчилдөө идэгдэж, эрх мэдлийн төлөөх бохир тэмцэлд орсны улмаас нийгмийг самууруулж  
 ард түмэн нийтээрээ мэдэх болжээ. Тэд урьдын адил сонгогчдын саналыг худалдан авах, хуурамч хөтөлбөр  
 өргөж олон түмнийг төөрөгдүүлэх зэрэг хуучин аргаа дахин хэрэглэхээр зэхэж байна. Монголчууд бид тэдэнд  
 хууртвал үндэсний сүйрэлд хүрэх аюултай тулгарна гэдгийг оицлон анхааруулж байна.

“ИРГЭНИЙ ЭВСЭЛ” Монгол дахь иргэний байгууллагууд, хөдөлгөөн, улс төрийн намуудын үзэл санаа,  
 ажилын туршлагыг судалж, монголын нөхцөл байдалд шинжилгээ, дүгнэлт хийсэн олон улсын байгууллага,  
 дотоодын эрдэмтдийн оюун сэтгэлгээний ололтөд тулгуурлан улс төрийн хөтөлбөрөө боловсруулж ард  
 түмэндээ толилуулаж байна.

Иргэний хөтөлбөр бөл зөвхөн энэ сонгуулийн төдийгүй, Монгол эх орноо аврах, сэргээн хөгжүүлэх шинжлэх  
 үндэстэй удаан хугацааны стратеги төлөвлөгөө бөгөөд монголчууд бидний оюун сэтгэлгээний бүтээл юм.

#### Иргэний зорилго, баримтлах зарчим



Монголын нийгэм гүнзгий хямралын улмаас гаж байдалд орж замбараагүйтлийн төлөв байдалд орсон гэж бид  
 үздэг байна. Нийгэм нэгэнт ийм гаж байдалд орсон учир гарах арга зам нь мөн шийдэмгий алхмыг шаардах болно.  
 Иргэний учир бид шүтэн барилдлага, уялдаа бүхий дараах тулгуур зарчмуудыг баримтлан ажиллах болно.

Монгол төрийн нэг гарт нь хуулийн ташуур, нөгөө гарт нь эиэрэнгүйн аяга байх ёстой. Монгол бол ядарсан  
 ядарсан нийгэм боллоо. Монгол бол гэмгүй биш, гэмт хэрэгжсэн засагтай нийгэм болж байна. Иймээс  
 Монгол Улсад эмх цэгц, дэг журмыг хатуу, туйлбартай аргаар тогтоох шаардлагатай. Монголд хуулийн  
 эрх зүйн тогтоох ёстой гэж бид үзэж байна.

Төрийн талаас Монголын төр нь өндөр настан, олон хүүхэдтэй эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй болон ядуу зүүдүү  
 нийгмийн эмзэг бүлгүүдээ хайрлан хамгаалж, энэрэнгүйн гараа харамгүй сунгах ёстой. Төр нь насанд  
 өсөн, боловсрол эзэмшсэн, бие эрүүл, хөдөлмөрийн чадвартай хүмүүсийг зүгээр тэжээх бус тэднийг ажлын  
 мөргөжил, орон байртай болгож, шударга тэнцүү гарааны нөхцлийг бүрдүүлэх үүрэг хүлээнэ.

Иргэний хатуу, зөөлөн энэ хоёр нүүрийг зөхистой хослуулах нь Монгол Улсын төрийн бодлогын гол зарчим  
 болно.

Нийгмийн тогтвортой байдлыг хангахын тулд зөвхөн эдийн засаг, улс төр төдийгүй үзэл санаа, ёс суртахуун, соёл  
 боловсрол, шинжлэх ухаан, спорт, эрүүл мэнд, гэр бүл, аюулгүй байдал, экологи зэрэг нийгэм бүрдүүлэгч  
 хүчин зүйлүүдийг цогцоор нь хөгжүүлэх шаардлагатай. Иргэдээ гэмт хэргээс  
 хамгаалж, эрүүл орчныг бүрдүүлэх нь Монгол төрийн эн тэргүүний зорилт юм.



## I. Хяналттай төр

### Иргэний хяналттай төрийн тогтолцоо

- ✓ Малчин, тариаланч, бизнес эрхлэгч, багш, эрдэмтэд зэрэг монголын нийгмийн гол давхрааг төлөөлсөн Иргэний танхимийг УИХ-ын дэргэд байгуулж, төрд зөвлөх, санал тавих өргөн эрхтэйгээр хуульчилна.
- ✓ Сонгуульт албан тушаалтныг эгүүлэн татах эрхийг сонгогчдод олгоно.
- ✓ Иргэдэд төрөөс учруулсан хохирлыг барагдуулах “Хариуцлагын сан”-г бий болгоно.

### Хүндээ үйлчилдэг төрийн байгууллага

- ✓ Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд тавих Иргэний хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.
- ✓ Хүнд суртлыг багасгаж иргэнийг төрийн аль ч шатны байгууллага, албан тушаалтан 20 минутаас илүү хүлээлгэхгүй, хоёроос дээш удаа явуулахгүй байх зэрэг төрийн үйлчилгээний хатуу журам, стандарт тогтоож мөрдүүлнэ.
- ✓ Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иээлтэй, хөнгөн шуурхай болгох зорилгоор төрийн үйлчилгээг Интернетээр авах нөхцлийг бүрэн бүрдүүлнэ.

### Иргэний мэдэх эрх

- ✓ Төрийн нууцаас бусад төрийн аль ч мэдээллийг иргэдэд ил тод байлгана.
- ✓ Гэмт үйлдлийн шинжтэй мэдээллийг төрийн нууцад хамааруулах явдлыг таслан зогсоож олон нийтэд худал болон зөрчилтэй мэдээлэл өгсөн, мэдээллийг нуун дарагдуулсан, хоцроосон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэг болно.
- ✓ Олон нийтийн радио, телевизийг улс төрчдийн хяналтаас бүрэн гаргаж, хүчирхийлэл, садар самуун, гаж үйлдэл зэргийг өдөөгч мэдээллийн терроризмыг таслан зогсооно.

### Иргэний ажлын зааг

- ✓ Төрийн албан хаагчдыг намын харьяаллаас гаргаж, улс төрийн намуудыг хатуу гишүүнчлэлгүй, ил тод, нийгмийн хяналттай болгоно.
- ✓ Төрийн захиргааны байгууллага болон намын аппаратын ажилтан Иргэдийн төлөөлөгчдийн байгууллагад сонгогдохыг хориглоно.
- ✓ Төв болон орон нутгийн засаглалын байгууллагад улс төрчид, албан тушаалтнууд давхар сонгогдох, ижиллахыг болиулна.

### Иргэний санал асуулга

- ✓ Сонгуулийн хувь тэнцүүлэх тогтолцоонд шилжиж, сонгуулийн байгууллагыг улс төрийн намуудын төлөөллөөс ангижруулна.
- ✓ Сум, хорооны түвшний сонгуульд улс төрийн намуудын оролцоог халж, иргэд засаг даргаа шууд сонгодог болгоно.
- ✓ Иүх нийтийн болон нийгмийн бүлгүүдийн санал асуулгын сүлжээг бий болгож, хөгжүүлнэ.

### Амьжиргаагай өрх

Монголын өрх бүрийг “Хөгжлийн босгоор” алхуулж, иргэн төвтэй төрийн бодлогын гол хэмжүүр болгоно. “Хөгжлийн босго” буюу монгол өрхийн доод үзүүлэлтийг:


**1. Сарын НЭГ сая төгрөгөөс доошгүй орлого**

**2. ХОЁР өрөө байр**

**3. Хүүхэд бүрт ГУРВАН халамж (эрүүл мэнд, боловсрол, цэвэр хүнс)**

Энэ томъёолж байна. Энэхүү “Хөгжлийн босго”-ыг нийгмийн болон байгалийн баялгийг шударгаар

ашиглах, авилгалын сүлжээг эвдэх, далд эдийн засгийг ил болгох дараах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх бүрэн боломжтой. “Хөгжлийн босго 1-2-3” зорилтыг хэрэгжүүлэх үндсэн чиглэл:





**Үүний хөгжил**

- ✓ Гэр бүлийг дэмжих бодлогыг хатуу баримталж нийгмийн хараа хяналтаас гадуур хүүхэдгүй болно. Хойч үеэ бодох тууштай зарчим баримтална.
- ✓ Боловсролын салбарт эрс шинэчлэл хийж, хүн бүрийг мэргэжилтэй, өрсөлдөх чадвартай болгох төрийн бодлого хэрэгжүүлнэ.
- ✓ “Тэгш боломж” нийгмийн зээлийн сан байгуулж иргэдэд өөрийгөө хөгжүүлэх, бизнесээ нээх гарааны зээлийн үндэсний тогтолцоог бүрдүүлнэ.

**Цалин сууц**

- ✓ Ажилтай залуу гэр бүл бүрийг байртай болгох, тэдэнд урьдчилсан төлбөргүй, бага хүүтэй, 15 жилийн хугацаатай зээл олгох тогтолцоог бүрдүүлнэ.
- ✓ Хашааны газрыг хувьд бүрэн шилжүүлж иргэдийн хяналт, оролцоотой “Газраа байраар сольё” хөтөлбөрийг хуульчлан хэрэгжүүлнэ.
- ✓ Улаанбаатар хотын төвлөрлийг багасгаж, хурдны замаар холбогдсон хувийн байшингийн хороолол, дагуул хотхонуудыг үүсгэнэ.

**Бизнес, аж ахуй**

- ✓ Үндэсний үйлдвэр, хөдөө аж ахуйг шинэчлэн сэргээн байгуулж, өрсөлдөх чадвартай, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тэргүүлэн хөгжүүлнэ.
- ✓ Аж ахуй дахь төрийн хэт оролцоог хязгаарлаж, бизнесийн салбар дахь хамтын хариуцлага, нийтлэг эрх ашгийн тогтолцоог бүрдүүлэгч “Үйлдвэрлэл, үйлчилгээний холбоодын (ҮҮХ) хууль”-ийг гаргаж, лиценз олголт, мэргэжлийн хяналтыг ҮҮХ-д шилжүүлнэ.
- ✓ Газрыг аж ахуйн эргэлтэд оруулж, хөдөөгийн өрх бүрийг өөрийгөө тэтгэх аж ахуйтай болгоно.

**Бичгийн эсрэг**

- ✓ Гэр хорооллын цахилгааныг шөнийн цагаар үнэгүй болгоно.
- ✓ Уул уурхайн ашиг орлогоос ондөр настан, ахмадуудад тэргүүн ээлжинд хүргэнэ.
- ✓ Байгалийн нөхөн сэргээлт, ойжуулалт, хот орчныг цэвэрлэх ажилд иргэдийг өргөнөөр татан оролцуулж цалинжуулах, мэргэшүүлэх урт хугацааны хөтөлбөр хэрэгжүүлнэ.


**Нийтэй нутаг**

**Бичгийн оорөө удирдах зарчим**

- ✓ ИТХ-уудын эрх мэдэл, хариуцлагыг нэмэгдүүлж, орон нутгийн татварын шинэ төгтолцоог бий болгоно.
- ✓ Хөдөө орон нутагт жижиг бизнес, аж ахуй эрхлэгчдийг татвараас бүрэн чөлөөлнө.
- ✓ Байгалийн баялгийн ашиглалтын асуудлыг орон нутгийн иргэдийн саналыг тусган шийдвэрлэж байх эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ.

**Бичгийн орчин, экологи**

- ✓ Даян дэлхийн экологийн глобал өөрчлөлтүүдийг тооцон, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
- ✓ Байгалийн баялгийн ашиглалтын өнөөгийн тогтолцоог бүрэн өөрчилж, экологийн урамшуулал, татвар, этандартын тогтолцоог бий болгоно. Экологийн цагдаагийн албыг байгуулна.
- ✓ Өнөөгийн экологийн сүйрлийг таслан зогсооно. Байгальд учруулсан хор уршгийг арилгах, арилгуулах эрс шийдэмгий арга хэмжээ авна.



2008.05.15

*Уул уурхай, газар*

- ✓ Хариуцлагатай уул уурхайг эрчимтэй хөгжүүлнэ
- ✓ Хууль бус олгогдсон бүх лицензийг хурааж, лицензийн наймааг бүрэн хална.
- ✓ Газрын далд наймааг бүрэн зогсооно.

**Эрүүл төр, эрүүл амьдрал, эрүүл нутгийнхаа төлөө хамтдаа тэмцье. Эх орноо цэвэрлэе.  
Та бид чадна.**

